

УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Барилга, хот байгуулалтын яам

2022 оны 3-р улирал

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
3. Эдийн засгийн бодлого							
1	3.7. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	3.7.1. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх	Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх	Зураг төслийг батлуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.	-	Багахангай дүүрэгт шилний үйлдвэр байгуулах “Эрдэс плазма” ХХК-ийн төслийг дэмжин, үйлдвэрлэл, технологийн паркийн орчинд ажиллах боломж, давуу талыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, дэмжигдсэн. Тус компанид Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 227 дугаар тогтоолоор ҮТП-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосон. 2022 онд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: Санхүүжүүлэгч байгууллагууд болох Дэлхийн банк, Хөгжлийн банкны шаардлагыг хангахын тулд үндсэн түүхий эдийн ордуудад А лиценз авч, ашиглалтыг эхлүүлэх шаардлагатай байна. Иймээс Дундговь аймгийн Өлзийтийн кварцын ордод хийсэн хайгуулын ажлыг 2021 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн /ЭБМЗ/ хурлаар хэлэлцүүлж, нөөцийн тайланг улсын бүртгэлд бүртгүүлсэн. Дорноговь аймгийн Сайхандулааны кварцын ордын нөөцийн тайланг 2022 онд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Үндсэн түүхий эдийн нэг болох Налайхын Элстэйн цахиурын элсний ордын ТЭЗҮ-ийг 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдөр УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны байгаль орчны үнэлгээний комиссын хурлаар 2022 оны 6 дугаар сарын 7-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан. Энэ ордын ашиглалтад шаардлагатай байгаа цахилгаан эрчим хүчний Техникийн нөхцөл олгоход дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 3/2885 тоотоор “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д хүргүүлсэн. Үндсэн түүхий эд	ББМҮБХЗГ 0

						<p>болох судлын кварцын ордод хийсэн судалгааны ажлыг 2021 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, нөөцийн тайланг улсын бүртгэлд бүртгүүлсэн. Шилний үйлдвэрийн үндсэн түүхий эд болох цахиурын элсний ордын ТЭЗҮ-ийг 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. 2022 оны зорилтот түвшиндээ хүрээгүй боловч тус яам хариуцах асуудлын хүрээнд ажлаа хийсэн болно.</p>	
2		<p>3.7.2. Батлан хамгаалах, газар хамгаалах, газар зохион байгуулалт, хот зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах</p>	<p>Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах</p>	<p>Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулсан байна.</p>		<p>2022 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төсвийн төсөлд тусгуулахаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын саналыг Барилга, хот байгуулалтын сайдын 2021.05.31-ний өдрийн 1/2037 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд уг төсөл, арга хэмжээний төсөв тусгагдаж батлагдаагүй тул дараах ажлуудыг хэсэгчлэн болон бусад төсөл арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх санал, тооцооллыг хийж, холбогдох ажлыг зохион байгуулж байна. Үүнд: 1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 289 дүгээр /маш нууц/ тогтоолын дагуу Монгол Улс, Оросын холбооны улс хоорондын улсын хилийг хамтран шалгах ажлын хүрээнд нийт 8 аймгийн 36 сумын хилийн дагуух нутаг дэвсгэрийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлыг гүйцэтгэх зардлын тооцоо, ажлын иж бүрдлийн жагсаалтыг гаргаж 2021.11.09-ний өдрийн МН/96 тоот /маш нууцын зэрэглэлтэй/ албан бичгээр Сангийн яам болон Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлсэн. Хянаж, шийдвэрлэх шатанд байна. 2. Тус яамнаас боомтыг хөгжүүлэх, шинээр барихаар төлөвлөсөн олон улсын транзит хурдны зам, хилийн боомтуудыг холбох хатуу хучилттай авто замын дагуу GNSS-ийн сүлжээ байгуулах, Монгол орны нутаг дэвсгэрийн 12 хувь буюу 185870.4 км.кв талбайд 2031 хуудас 1:25000-ны масштабтай байр зүйн зураг гүйцэтгэж, орон зайн мэдээллийн сан байгуулах саналыг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга</p>	<p>ХБГХБХЗГ 30</p>

						байгууламжийн жагсаалтад тусгуулахаар саналаа 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/2486 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 3. "Геодези, зураг зүйн салбарт хамтран ажиллах тухай" Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /нууцын зэрэглэлтэй/-ийг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын гишүүдээс санал авч тусган, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгээд байна. Энэхүү хэлэлцээрийн төсөлд байр зүйн зураг зохиох чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг тусгаад байна.	
3		3.7.3. Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулан, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулах	Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулан, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулах	Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг аймаг, нийслэлд үргэлжлүүлэн хийнэ /405 барилга/.		Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ыг шинэчлэн боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 127 дугаар тушаалаар батлуулсан. Улсын хэмжээнд олон нийтийн зориулалттай 18,442 барилга байгууламж байгаагаас нийслэлийн хэмжээнд 9,821, орон нутгийн хэмжээнд 8,621 барилга байгууламж байна. Үүнээс 2002 оноос өмнө баригдсан олон нийтийн барилга нийслэлд 1844, орон нутагт 5828 байна. Нийслэлд 2011-2021 онд орон сууцны 640, олон нийтийн 216, нийт 856 барилгад буюу 46 хувьд нь судалгаа хийн, дүгнэлт гаргаж, паспортжуулсан. Дээрх 856 барилгаас газар хөдлөлтөнд тэсвэртэй 199, бэхлэгээ хийж, хүчитгэх шаардлагатай 162, тэсвэргүй 495 барилга байна. Цаашид нийслэлийн 988 олон нийтийн барилга байгууламжийг паспортжуулахад 6,9 тэрбум төгрөг, аймаг орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн 2142 барилга байгууламжийг паспортжуулахад 14,9 тэрбум төгрөг тус тус шаардлагатай байна. Энэхүү танилцуулгыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Барилга байгууламжийг паспортжуулах ажилд шаардлагатай санхүүжилтийг 2021 оны улсын төсөвт тусгах саналаа 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2671 тоот албан	ББМҮБХЗГ 30

					<p>бичгээр хүргүүлсэн бөгөөд үүнээс 200 сая төгрөг Барилга, хот байгуулалтын сайдын багцад туссан. Үүнээс 50 барилга байгууламжид мэргэжлийн дүгнэлт гаргаж паспортжуулсан. 2022 оны улсын төсөвт тусгах саналаа 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 тоот албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/171 дүгээр захирамж, Хот байгуулалт хөгжлийн Газрын даргын 2022 оны “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/04 дүгээр тушаалын дагуу 172 барилгын бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах 5 багц ажил тендерийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2 удаа зарлаж, 1 аж ахуй нэгж үнийн санал ирүүлсэн боловч тендерийн баримт бичгийн иж бүрдэл дутуу, шаардлага хангаагүй учир тендер амжилтгүй болсон. Улмаар төсвийн тодотголоор хөрөнгө нь татагдаад байна.</p> <p>2023 онд Улсын төсөвт барилга байгууламжийг паспортжуулахад шаардлагатай байгаа 1 тэрбум 620 сая төгрөгийн саналыг Барилга, хот байгуулалтын яамнаас 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 1/3787 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	
4		3.7.4. Газар ашиглалт, газрын мониторинг ийн байнгын ажиллагаат ай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог	Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих	Мониторинг ийн сүлжээний 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын судалгааг хийж, хөрсний хяналт-шинжилгээн ий улсын 1	<p>2022 онд Улсын хэмжээнд хот суурин газрын мониторингийн 300 цэг, тариалангийн газрын мониторингийн 100 цэг, бэлчээрийн газрын мониторингийн 100 цэг нийт мониторингийн сүлжээний 500 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:</p> <p>1.Нийслэлийн 7 дүүргийн хөрсний бохирдолд өртсөн байж болзошгүй мониторингийн 300 цэгт хянан баталгааны ажлыг хийхээр төлөвлөн хээрийн судалгааны ажлыг 7-8 сарын хооронд гүйцэтгэсэн. Хээрийн судалгааны ажлын удирдамжийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр ГЗБГЗЗГ-ын даргаар батлуулан удирдамжийн дагуу Нийслэл болон 7</p>	ХБГХБХЗГ 50

		<p>бүрдүүлэн хяналт тавих</p>		<p>лаборатори йг Төвийн бүсэд байгуулсан байна.</p>	<p>дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>-Газрын мониторингийн үндэсний сүлжээний тариалангийн газрын мониторингийн 100 цэгт спектрометрийн хэмжилт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын даалгаврыг АД/2022-14 дугаартайгаар баталж, Геоэкологийн хүрээлэнгийн Зайнаас тандан судлал, Орон зайн загварчлалын салбартай зөвлөх үйлчилгээний 2022/121 дугаартай гэрээг байгуулан ажиллаж байна.Тухайн гэрээт ажлын хүрээнд Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн тариалангийн 100 цэгт гүйцэтгэгч байгууллага 7-8 сард хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>-Бэлчээрийн газрын мониторингийн 100 цэгт спектрометрийн хэмжилт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын байршлыг сонгож, 8-9 дүгээр сард хээрийн судалгааны ажлыг хийхээр удирдамжийг боловсруулсан.</p> <p>2.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны үйл ажиллагааг цахим хэлбэрээр гүйцэтгэж, улсын хэмжээнд иргэн, хуулийн этгээдийн захиалгаар эрх бүхий мэргэжлийн байгууллагуудын хийж гүйцэтгэсэн нийт 5630 тайланг цахим системээр баталгаажуулсан.</p> <p>3.Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 126 дугаар тушаалаар "Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар"-ыг батлуулсан. Хяналт-шинжилгээний лаборатори байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна.</p> <p>Газрын төлөв байдал, чанарын судалгааг хийж, хөрсний хяналт-шинжилгээний лабораториудыг байгуулах ажилд шаардагдах 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2023 оны улсын төсөвт тусгах саналыг БХБСайдын 2022.05.31-ний өдрийн 1/2684 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	
--	--	---------------------------------------	--	---	--	--

5		3.7.5. Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	ХХяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна.	Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих, автоматжуулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд: 1. Улаанбаатар хотын БГД-ийн ус түгээх байруудыг усны нөөц санд холбох зураг төслийг боловсруулж байна; 2. Сумын хөгжил төсөл: Увсын Зүүнхангай суманд ухаалаг худаг барих ажлын гүйцэтгэл 70%-тай, Наранбулаг-50 сая.төг, Архангайн Хангай, Жаргалант, Тариат, Цахир 42 сая.төг, Улаанбаатар хотын БЗД-т ухаалаг ус түгээх байр, гүний худаг шинээр барих 90 сая.төг. Гүйцэтгэл 72%-тай; 3. Ус хангамжийн шугам сүлжээ: Дорноговь-1700 сая.төг, Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд цэвэр усны 1,5 км шугам сүлжээ шинээр барих ажил, Төв аймгийн төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг, усан сан, насосны станц, шугам сүлжээ шинээр барих ажлын гүйцэтгэл 60%-тай. Завхан аймгийн төвийн 21-р зуун хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажил 70%-тай, Сүхбаатар-339.8 сая.төг, Баян-Өлгий аймгийн төвд цэвэр усны шугам сүлжээ барих ажлын зураг төслийг болловсруулсан. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд ус хангамжийн 1,2 км шугам сүлжээг барьж, мөн аймгийн Цагаан-Уул суманд цэвэр усны 4,2 км шугам сүлжээ, усан сан барих ажлыг гүйцэтгэн 2022.09.14-нд тус тус байнгын ашиглалтад оруулсан. 2022 онд 3,005.8 сая.төг-ийн санхүүжилт олгосон.	НААИДББХЗГ 90
6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого						
6	6.1. Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын	6.1.1. “Дэнжийн мянга дэд төв”, “Дамбадаржаа дэд төв” төслийг хэрэгжүүлэх	“Дэнжийн мянга дэд төв”, “Дамбадаржаа дэд төв” төслийг хэрэгжүүлэх	Төслийн гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	- <u>Дэнжийн мянга дэд төв:</u> Газар чөлөөлөх нөхөн олговрын хөрөнгө шийдэгдээгүй тул 2022 оны эхний хагас жилд ажил хийгдээгүй. Нарийвчилсан ажлын зураг боловсруулж батлуулах ажил хийгдэж дууссан. <u>Дамбадаржаа дэд төв:</u> Монгол улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Санхүүжилтын ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд НЗДТГ-ын хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 16, 17	НААИДББХЗГ 70

	таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.					дугаар хорооны нутаг дэвсгэрт 70.7 га газарт Дамбадаржаа дэд төв төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 2 эгнээ авто зам 2.8 км, 4ш ус дулаан дамжуулах төв, дулаан хангамжийн шугам 2.6 км, цэвэр усны шугам 2.3 км, бохир усны шугам 3 км, цахилгааны шугам 6.6 км, үерийн хамгаалалтын далан 2.1 км, хөрсний ус доошлуулах шугам 1.5 км, цахилгаан хангамжийн 10/0,4 кВ хаалттай дэд өртөө 2ш, холбооны шугам 5.9 км, д 63 МВт-ын хүчин чадалтай дулааны станц тус тус хийхээр төлөвлөсөн. Дулааны станцын ТЭЗҮ батлагдсан, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийгдсэн, зураг төсөл боловсруулах ажлын явц 100% дууссан. Дамбадаржаа дэд төвийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 63%, худалдан авах ажиллагааны явц 59%, инженерийн нарийвчилсан зураг боловсруулж батлуулах ажлын явц 95%, барилга угсралтын ажлын явц 32%-тай хэрэгжиж байна. Нийт: 121.14 сая. ам доллар. Зарцуулалт: 32.47 сая. ам доллар.	
7	6.1.4. АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг барих төслийг хэрэгжүүлэх	АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг барих төслийг хэрэгжүүлэх	Төслийн гүйцэтгэл 15 хувьд хүрсэн байна.	Улсын төсөв - 40,0 сая төгрөг, Гадаадын зээл, тусламж - 28,4 тэрбум төгрөг	АНУ-ын МСК-ын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр нь дараах 3 төслөөс бүрддэг. Үүнд: 1.Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр барих төсөл; 2.Хаягдал усыг дахин боловсруулах байгууламжийг шинээр барих төсөл; 3.Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл зэрэг болно. 1.Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр барих төсөл: УБ хотын Биокомбинат, Шувуун фабрик орчмын усны ордыг түшиглэн ундны усны 2 шинэ эх үүсвэрийн нийт 30 худаг, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх байгууламжийг барьж, нийслэлийн ус хангамжийг жилд 50 сая орчим м3-ээр нэмэгдүүлнэ.Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч МАПА компани нь төслийн талбайд 2021.09 сараас эхлэн дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: -Үндсэн 3-н барилгын суурийн хэсгийн газар шорооны ажил 100%;	НААИДББХЗГ 100	

						<p>-Төслийн талбайн барилга угсралтын үеийн түр цахилгаан хангамжийг бүрэн шийдвэрлэсэн;</p> <p>-Үерийн ус зайлуулах 1500 мм голчтой бетон шугамын суурилуулалт 100%;</p> <p>-Урвуу осмосын барилга, үйлдвэрийн барилга, усан сангийн суурийн болон ханын цутгалтын ажлыг гүйцэтгэж эхлэсэн.</p> <p>-Нийт 36100м3 бетон цутгалтын ажил гүйцэтгэхээс 14000м3 цутгасан.</p> <p>-Дотоодын 7 компани туслан гүйцэтгэгчээр ажиллаж байна. Ажлын явц 18%-тай. Одоогийн байдлаар үйлдвэрийн барилга, урвуу осмосын барилга, усан сангийн барилгуудын суурийн болон ханын бетон цутгалтын ажил үргэлжилж байна.</p>	
8		6.1.5. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд “Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийг хэрэгжүүлэх	Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд “Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийг хэрэгжүүлэх	Төслийн гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.	Улсын төсөв - 1,2 тэрбум төгрөг	<p>Тус төслийн ТЭЗҮ, барилгын зураг төслийг 2019 онд батлуулсан. БНХАУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хооронд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэх тухай “Солилцох захидал”-ыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр байгуулсан. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Засгийн газар хооронд 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр “Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх албан протокол”-ыг байгуулсан. Монголын тал дээрх эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу Монголын талын хариуцах бэлтгэл ажлыг 100% хангасан. Төслийн менежментийн компанийн 2 ажилтан, Ерөнхий гүйцэтгэгч байгууллагын удирдах 4 ажилтан Солонгосын Сөүл хотоор дамжин 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Монгол улсад хүрэлцэн ирсэн. Барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд эхний ээлжийн барилгажих талбайн газрыг бүрэн чөлөөлж, барилгын талбайг цэвэрлэж, барилгын түр хашаа, инженер техникийн ажилчдын түр байр болон талбай доторх түр зам барьж, барилгын ажил эхлүүлэхэд бэлэн болгосон. Мөн цахилгаан, дулаан, ус хангамж зэрэг инженерийн дэд</p>	ББМҮБХЗГ 50

						бүтцээр хангах техникийн нөхцлүүдийг холбогдох байгууллагуудаас авсан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн 784,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11 айлын газрыг чөлөөлж, барилгажих талбайн газрыг бүрэн чөлөөлж, барилгын материал, тоног төхөөрөмжийн татан авалтыг хийж, төслийг хэрэгжүүлж байна. 2022 оны 9-р сарын байдлаар төслийн хүрээнд баригдах 8 блок барилгын хавтан суурь 100%, хайрцаган суурь 100%, хайрцган суурийн хучилт /8-1 үлдсэн/ 90%, 1,2-р блокын зоорийн давхрын ханын арматурчлалын ажил 80%, 1-8 дугаар блокын хайрцган суурийн хайргын чигжээсийн ажил-100% хийгдээд байна. Төслийн хэрэгжилт 20%.	
9	6.1.6. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30000 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх	Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30000 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх	Зураг төсөл, инженерийн бэлтгэл арга хэмжээг бүрэн дуусгаж, төр-хувийн хэвшлийн түншлэлээр бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна.	2022 оны улсын төсөвт 29,9 тэрбум төгрөг батлагдсан. 2022.06.01-ны байдлаар санхүүжилт хийгдээгүй байна.	“Залуус 1” орон сууцны хорооллын техник эдийн засгийн урьдчилсан судалгааг 2021.05.31-ний өдөр, архитектур төлөвлөлтийн даалгаврыг 2021.06.08-ны өдөр, эх загвар зургийг 2021.06.15-ны өдөр тус тус батлуулсан. Барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд инженерийн бэлтгэл арга хэмжээ, авто зам, замын доогуурх хонгилын систем, гадна инженерийн шугам сүлжээ, дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ болон орон сууцны барилгын ажлын зураг төслүүдийг олгогдсон техникийн нөхцөлийн дагуу 2021 онд нийт 1.6 тэрбум ₮-ийн хөрөнгө оруулалтаар боловсруулж батлуулсан. Хорооллын эхний ээлжийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд 2022 оны улсын төсөвт 29.9 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөг бүхий 3.6 тэрбум төгрөгийн санхүүжих эх үүсвэр батлагдсан. Энэхүү төсвийн хүрээнд төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, нийт 5 багц ажлаас 5 багц ажлын гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрийн хооронд байгуулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн. Үүнд: Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ - "Алтайн үндэс констракшн" ХХК (гүйцэтгэл 20 хувь), дулаан хангамжийн шугам сүлжээ - "Одкон холдинг" ХХК (гүйцэтгэл 35 хувь), хонгилын систем - "Биг монголиа билдинг" ХХК (гүйцэтгэл 30 хувь), цахилгаан хангамжийн ажлыг “Би Эс Би Энержи” ХХК (гүйцэтгэл	ОССХ 100	

						10 хувь) тус тус шалгарч, тус онд санхүүжихээр батлагдсан төсвийн хүрээнд 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгоод байна. Мөн “Залуус-1” төслийн хүрээнд тус яамнаас Улсын 2023 оны төсвийн төсөлд үлдэгдэл санхүүжилт 26.3 тэрбум төгрөг, шинээр хэрэгжүүлэх 37.3 тэрбум төгрөг, нийт 53.6 тэрбум төгрөгийн дэд бүтэц, шугам сүлжээний ажлын санхүүжилтийг тусгуулахаар Сангийн яаманд санал хүргүүлээд байна.	
10	6.1.7. Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлын үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. Үерийн 1.7 км далан /Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/-г барьж ашиглалтад оруулсан байна. Хайлаастын авто замын ус зайлуулах 1.5 км цутгамал төмөр бетон суваг /Чингэлтэй дүүрэг, 13	Санхүүжилтийн үлдэгдэл 2022 оны эхний хагас жилд олгогдоогүй байна.	1. Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулж дуусган Барилгын хөгжлийн төвийн 2022 оны ЭЗ-0001/2022 тоот магадлалын дүгнэлтээр баталгаажсан. Төсөвт өртөг: 1,2 тэрбум төгрөг. Санхүүжилт олгогдсон байдал - 1.08 тэрбум төгрөгийн олгогдсоноос 2021 онд 772,2 сая төгрөг, 2022 онд 308 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгогдсон. 2. Үерийн 1.7 км далан /Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/: Төсөвт өртөг - 2,6 тэрбум төгрөг. Барилга угсралтын ажил 100 хувь. Санхүүжилтийн 100 хувь олгогдсон байна. 3. Хайлаастын авто замын ус зайлуулах 1.5 км цутгамал төмөр бетон суваг /Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо/-ийг барих ажил: Төсөвт өртөг - 799,3 сая төгрөг. Барилга угсралтын ажил 100 хувь.	НААИДББХЗГ 100	

				дугаар хороо/-ийг барьж ашиглалтад оруулсан байна.			
11		6.1.11. Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн 2475 айлын гадна инженерийн шугам сүлжээг барих	Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн 2475 айлын гадна инженерийн шугам сүлжээг барих	2475 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээ	Улсын төсөв - 500,0 сая төгрөг	<p>Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд Баянзүрх дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэр Амгалан орчмын дэд бүтцийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажил нь 2013 оноос хойш үе шаттайгаар хэрэгжиж байна. Төслийн нийт өртөг 11589.9 сая төгрөг, ажлын гүйцэтгэл 79%, 2022 оны санхүүжилт 500 сая төгрөг. Уг төсөл хэрэгжсэнээр нийт 236 нэгж талбар бүхий 15.2 га талбайд 49 блок 3138 айлын орон сууц, 1800 хүүхдийн сургууль, 800 хүүхдийн цэцэрлэг барих боломж бүрдэнэ.</p> <p>"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хүрээнд гэр хорооллын инженерийн шугам сүлжээний дараах 10 арга хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>Үүнд: 1. Орлогод нийцсэн 20 айлын орон сууцны барилга дуусах хугацаа 2022.05.25. Хэрэгжилт 100% бүрэн дууссан.;</p> <p>2. Зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугам болон бохир усны шугамын ажил. Дуусах хугацаа 2022.11.30. Хэрэгжилт 70%;</p> <p>3. Тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугамын ажил. Дуусах хугацаа 2022.11.30. Хэрэгжилт 83.5%;</p> <p>4. Баянхошуу дэд төвд түрээсийн 2 блок 126 айлын орон сууцны барилга. Дуусах хугацаа 2022.10.22. Хэрэгжилт 81%;</p> <p>5. Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийг инженерийн шугам сүлжээгээр хангах ажил. Дуусах хугацаа 2022.10.23. Хэрэгжилт 84%;</p>	НААИДББХЗГ 90

					<p>6. Баянхошуу дэд төв дэх нийгмийн барилга байгууламжийн ус, дулаан хангамж, ариутгах татуургын шугамын угсралт. Дуусах хугацаа 2022.10.26. Хэрэгжилт 56.25%.</p> <p>7. Сэлбэ дэд төвийн 2-р хэлхээний инженерийн шугам сүлжээний угсралтын ажил. Дуусах хугацаа 2022.07.01. Хэрэгжилт 100% бүрэн дууссан.</p> <p>8. Дамбадаржаа дэд төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам нийлүүлэх ажил. Дуусах хугацаа 2022.08.30. Хэрэгжилт 30%.</p> <p>9. Дамбадаржаа дэд төвийн үерийн хамгаалалтын далан. Дуусах хугацаа 2022.12.25. Хэрэгжилт 47%.</p> <p>10. Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын далан. Дуусах хугацаа 2022-10-30. Хэрэгжилт 48%-тай байна.</p>	
12	6.1.12. Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх	Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх	Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, төслийн зээлийн гэрээг байгуулж, санхүүжилтийг шийдвэрүүлж, төслийг эхлүүлсэн байна.	-	<p>Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг “Эм Эй Ди Урбан” ХХК /MAD Urban/-иар гүйцэтгүүлж, 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Мөн уг төслийн хөрөнгө оруулалтыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг НИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн тодотголд дээрх төслийг хэрэгжүүлэх талаар нэмэлт, өөрчлөлт оруулан Улсын Их Хуралд өргөн бариад байсан бөгөөд 2022 оны хаврын чуулганаар уг хөтөлбөрийн тодотголыг хэлэлцээд буцаасантай холбогдуулан төслийн санхүүжилт шийдвэрлэгдэх хугацаа хойшлоод байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2021-2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дахин нягтлан шалгаж байгаатай холбогдуулан тус төслийн хэрэгцээ шаардлагыг хүснэгтийн дагуу шинээр боловсруулан Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022 оны 06 дугаар сарын 8-ны өдөр хүргүүлсэн. Европын Сэргээн Босолт Хөгжлийн Банкны тендер, худалдан авалтын албаны төлөөлөлтэй төслийн хүрээнд зарлах тендерийн бичиг баримт, гэрээ болон ажлын даалгавар</p>	ОССХ 50

						<p>боловсруулалтын талаар уулзалт хийж, төслийн хэрэгжилтийн тусалцаа үзүүлэх зөвлөх сонгон шалгаруулах тендерийн ажлын даалгаврыг боловсруулж батлуулан, тендерийг 2022 оны 10 дугаар сард зарлахаар бэлтгэж байна. Төслийн зээлийн хэлэлцээр байгуулах албан хүсэлтийг Европын Сэргээн Босолт Хөгжлийн Банкнаас Сангийн яаманд 2022 оны 08 дугаар сарын 04-ны өдөр хүргүүлсэн боловч Сангийн яам 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 03/5593 тоот албан бичгээр барилгын материалын өнөөгийн зах зээлийн дундаж үнэ ТЭЗҮ-д тооцоологдсон үнийн дүнгээс 20 хувиар илүү байгаа тул анх төлөвлөж байсан санхүүжилтын дүнд багтаан төслийн ТЭЗҮ-г дахин боловсруулах зөвлөмжийг НЗДТГ-т хүргүүлсэн байна.</p>	
13	6.1.13. “Шинэ Зуунмод” хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх	“Шинэ Зуунмод” хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтцийн зураг төслийг боловсруулсан байна.	Улсын төсөв - 2,1 тэрбум төгрөг	<p>Дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: 1.Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор батлуулсан. 2.Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх “Чингис хаан” шинэ нисэх буудлыг түшиглэн 1000 га газарт Хөшигийн хөндийн Эдийн засгийн чөлөөт бүсийг УИХ-ын 2022.04.07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор байгуулсан; 3.Төрийн захиргааны зарим байгууллагын ажиллах нэгдсэн байрыг Төв аймгийн Хөшигийн хөндийрүү нүүлгэн шилжүүлэх тухай ЗГ-ын 2022.03.09-ний өдрийн 98-р тогтоол гарсан. Энэ ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамнаас “Хөшгийн хөндийд Засгийн газрын шинэ ордон байгуулах ажлын зураг төсөл” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж, ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хураангуй жагсаалт үүсгэх тендерийг 2022.09.09-ний өдөр зарлаж 2022.09.21-ний өдөр сонгон шалгаруулна. /Монгол Улсын 2022-2023 оны төсөвт 1,2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн./</p> <p>4.ЗГ-ын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор баталсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд “Орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий</p>	ХБГХБХЗГ 100	

					<p>төлөвлөгөө боловсруулах” ажил, /200.0 сая төг/, “Эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” /234.0 сая төг/, “Тээвэр, логикийн төвийн ТЭЗҮ, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” /339.6 сая төг/-ний ажлын явц 70 хувьтай байна. “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө /700.0сая төг/ боловсруулах ажил 2022оны 5-р сараас эхлээд байна. Ажлын явц 30%.</p> <p>5. Шинэ Зуунмод хотын ИДБ, ИШС-ний зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд: Эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөл "Хайдродизайн прожект" ХХК боловсруулж байна. Зураг төслийн явц-100%, эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл "Наран рашаан" ХХК, "Оргил төсөл" ХХК, "Инженер геодези" ХХК боловсруулж байна, явц-90%, эхний ээлжийн ус хангамжийн зураг төсөл "Престиж инженеринг" ХХК боловсруулсан, явц-100%, эхний ээлжийн мэдээлэл холбооны ажлын зураг төсөл "Анга транс" ХХК боловсруулсан, явц-100%, эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл "Баясал төгс" ХХК боловсруулсан, явц-100%, эхний ээлжийн дулаан хангамжийн ажлын зураг төсөл "Сээмий" ХХК, "Эрчим төсөл" ХХК боловсруулж байна, явц-90% байна.</p> <p>"Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээний ажил / Үерийн хамгаалалтын суваг-1,2,3,4/ ыг гүйцэтгэхэд шаардлагатай 8.7 тэрбум төгрөгийг 2022-2023 онд төсөвт тусгуулсан бөгөөд, гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулах ажил хийгдэж байна. Хотын эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажил - Хөндий 35кВ ЦДАШ, 35/10кВ-ын 2*10000кВА чадалтай "Хөндий" дэд станц, 110/35/10кВ-ын "Зуунмод" дэд станцын өргөтгөл /Төв/ ийн ажил гүйцэтгэхэд 2022 -2023 ондонд 12.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгагдсан, гүйцэтгэгчэр "Билгүүн од констракшн" ХХК шалгаран гэрээ байгуулж байна. Эхний ээлжийн ус хангамжийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай 11.8 тэрбум төгрөгийг 2022-</p>	
--	--	--	--	--	--	--

						2023 оны улсын төсөв тусгагдсан. Гүйцэтгэгчээр “Эс энд Эй трейд” ХХК шалгарч, гэрээ байгуулж байна.	
14	6.2. Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	6.2.3. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд 11 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд 11 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Төслийн гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.	АХБ - 25,7 тэрбум төгрөг	АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгээд байна Үүнд: 1. Архангай, Өвөрхангай аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралт, тохируулга зүгшрүүлэлтийн ажил 100 хувь дууссан. Ашиглалтын байгууллага хариуцан ажиллуулж байна. 2.Булган аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 100%, тохируулга зүгшрүүлэлт 66%, Өмнөговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 100%, тохируулга зүгшрүүлэлт 66%, Хөвсгөл аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 100%, тохиргуулга зүгшрүүлэлт 80%, 3. Хэнтий аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 100%, тохируулга зүгшрүүлэлт 75%-тай байна. 4.Дорноговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 100%, тохируулга зүгшрүүлэлт 15%-тай, Дундговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 100%, тохируулга зүгшрүүлэлтийн ажил 10%-тай Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 80%, Дархан-Уул аймгийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 78%-тай байна. 5.Өвөрхангай аймгийн Хужирт сумын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 85%, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэвэрлэх байгууламжийн ажил 100%, тохируулга зүгшрүүлэлт 15%-тай, 2022 онд 25,784.64 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.	НААИДББХЗГ 100
15		6.2.4. Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн	Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн	Төслийн гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.	Гадаадын зээл, тусламж - 3,8 сая евро	1. БНПУ-ын нөхцөлт зээлийн хөрөнгөөр Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил 70%-ийн гүйцэтгэлтэй, Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөл 50%-ийн гүйцэтгэлтэй байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар	НААИДББХЗГ 70

		шинээр барих төслийн хэрэгжилтийг 10 хувьд хүргэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/	хэрэгжилтийг 10 хувьд хүргэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/			3,809,142 еврогийн урьдчилгаа олгогдсон. Цэвэрлэх байгууламжийн БУА-ын нээлтийг 2022.09.20-ноос 22-ны өдрүүдэд Баян-Өлгий, Увс, Завхан аймагт хийсэн. 2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймгийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил 70%, Улаанбаатар хотын Багануур дүүргийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөл 80%, эдгээр 2 цэвэрлэх байгууламжийн зураг төслийн төсөвт өртөг 650 сая төгрөг. 3. Баянхонгор аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлын даалгавар боловсруулагдсан.	
16	6.2.5. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай эхлүүлэх	Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай эхлүүлэх	-Хэнтий аймгийн Хэрлэн суманд үерийн хамгаалалтын н 1000 у/м даланг барьж ашиглалтад оруулсан байна. - Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд үерийн хамгаалалтын н 1539.8 у/м сувгийг барьж ашиглалтад оруулсан байна. - Баянхонгор	Улсын төсөв - 6,2 тэрбум төгрөг	Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын далан барих ажлын хүрээнд: 1. Хэнтий аймгийн Хэрлэн суманд 10,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 14,7 км урттай үерийн далан барих ажлаас 7 км урт сувгийн ёроолын бетон цутгалт, газар шорооны ажил болон сувгийн доторлогооны бетон хавтанг цутгаж нийт 2,857,992,397 төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 2022 онд 1,463,347,597 төгрөгийн санхүүжилт олгогдоод байна. Уг төсөл, арга хэмжээ нь гүйцэтгэлийн гэрээний дагуу 2023 оны 11 сарын 01-ний өдөр дуусах юм. /Гүйцэтгэл 30%/ 2. Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд 580,9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 1519м урттай үерийн далан барих ажлаас 940 м урт сувгийн ёроолын бетон цутгалт хийж, 1840ш сувгийн хананы хавтан угсаран 440,3 сая төгрөгийн санхүүжилт олгогдоод байна. Гүйцэтгэл - 80%. 3. Баянхонгор аймгийн төвд ус хүлээн авах 3400 у/м цутгамал төмөр бетон сувгийг барьж ашиглалтад оруулсан. Гүйцэтгэл 100%. 4. Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 12,5 тэрбум төгрөгийн гэрээний дүн бүхий 11.7 км үерийн усны	НААИДББХЗГ 90	

				<p>аймгийн төвд ус хүлээн авах 3400 у/м цутгамал төмөр бетон сувгийг барьж ашиглалтад оруулсан байна. -Баян-Өлгий аймгийн төвийн 11735 у/м үерийн хамгаалалтын далан сувгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.</p>		<p>хамгаалалтын далан суваг барих ажлын гүйцэтгэл 54%-тай бөгөөд нийт 6.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 2022 онд 920 сая төгрөгийн санхүүжилт олгогдоод байна.</p>	
17	6.2.6. Ядуурлыг бууруулах Японы сангийн хөрөнгөөр тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах	Ядуурлыг бууруулах Японы сангийн тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах	Төслийн хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна.	АХБ - 6,8 тэр.төгрөг	<p>Төслийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Говь-Алтай аймагт хог хаягдлын хяналттай шинэ төвлөрсөн цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-100% 2. Сүхбаатар аймагт хог хаягдлын хяналттай шинэ төвлөрсөн цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-100% 3. Дархан-Уул аймгийн төвд дахивар хүлээн авах цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-100% 4. Говь-Алтай аймагт хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүү ба дахивар хүлээн авах цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-90% 5. Сүхбаатар аймагт хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүү ба дахивар хүлээн авах цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-100% 6. Өвөрхангай аймагт автопүү, дахивар хүлээн авах цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-100% байна. 	НААИДББХЗГ 90	

		төслийг хэрэгжүүлэх				<p>7. Олон нийтийн дадал бий болгох нөлөөллийн зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэл-85%</p> <p>Төслийн хүрээнд дахивар хаягдлыг боловруулах иргэдийн санаачлагыг дэмжих бичил тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн ба нийт 14 тэтгэлгийн гэрээг байгуулан 7-р сард бүх тэтгэлгийг олгосон. 9-р сард багтаан бичил тэтгэлгээр санхүүжилт олгосон иргэн албан байгууллага, нөхөрлөлүүд төлөвлөгөөт үйлвэрлэлээ эхлүүлнэ.</p> <p>Төслийн хүрээнд хатуу хаягдлын менежментийн зориулалтаар төслийн 4 аймагт тус бүр нэг ширхэг механизм 2022 оны 10 сард хүлээлгэн өгөхөөр худалдан авалтыг зохион байгуулж байна.</p> <p>Төслийн хэрэгжилт 89% байна.</p>	
18		6.2.7. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулах	Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулах	Түрээсийн орон сууц барих ажлыг үргэлжлүүлнэ .		<p>2022 оны хагас жилийн байдлаар 12 аймгийн 13 суманд 1630 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлээд байна. Аймгуудын төвд орон сууцны төсөл хэрэгжүүлэх, ашиглалтад оруулах орон сууцыг түрээслэх, түрээслээд өмчлөх хэлбэрээр зорилтот бүлгийн иргэдэд олгох зорилгын хүрээнд "ТОСК" ТӨХХК-аар дамжуулан аймгуудын Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран ажиллах санамж бичгийг байгуулан ажиллаж байна. Үүнд, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан 2021.11.24-ний өдрийн 01/2021 дугаар санамж бичиг, Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай 2021.12.09-ны өдрийн 2021/101 дугаартай санамж бичиг, Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан 2022.01.13-ны өдрийн санамж бичиг. Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд тус аймгийн Цогтцэций суманд эрчим хүчний хэмнэлттэй 10 айлын амины орон сууцны төслийн урьдчилсан тооцоолол, зураг төслийг боловсруулж, төслийн санхүүжилтийг сумын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэхээр ажиллаж байна. Тус аймгийн Даланзадгад суманд хэрэгжих эрчим хүчний хэмнэлттэй 90 айлын амины орон сууцны хотхоны эхний ээлжийн 10 айлын орон сууцыг хувийн хэвшлийн</p>	ОССХ 90

						байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангагдаж байна. Мөн Сайдын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 1/2638 тоот бичгээр “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хөдөө, орон нутагт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцээр хангагдсан, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төслүүдийг хэрэгжүүлэхэд нь газар, дэд бүтэц болон бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах чиглэлийг аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн.	
19	6.2.9. “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 суманд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах	“Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 суманд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах	Төслийг 18 сумын төвд хэрэгжүүлнэ.	Барилга угсралтын ажлын нийт төсөвт өртөг 81,800.0 сая төгрөг. 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар санхүүжсэн 4,911.0 сая төгрөг байна. Зураг төсөл боловсруулах ажлын нийт төсөвт өртөг 1,477.6 сая төгрөг. 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар санхүүжсэн 608.0 сая төгрөг байна.	<p><u>I. Мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр:</u> “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” сэдэвт хэлэлцүүлгийг холбогдох төрийн байгууллагууд, төсөл хэрэгжсэн болон хэрэгжих аймаг, сумдын төлөөлөл, зураг төслийн байгууллага, салбарын төрийн бус байгууллагуудыг оролцуулан 2022 оны 03 дугаар 29-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт ЭЗХЯ, ЭХЯ, БОАЖЯ, СЯ, БШУЯ, ХСУХАТАУЗЗ, ЭХЗХ, ГЗБГЗЗГ, ХХЕГ, БХТ, Усны газар болон 19 аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга нар, Аймгийн Ерөнхий архитекторууд, ГХБХБГ-н газрын болон НААҮБ-ын дарга нар, нийт 93 сумдын Засаг дарга нар нийт 2оролцож, цаашид сумын инженерийн дэд бүтцийн барьж байгуулах, ашиглах явцад анхаарах тулгамдсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар санал бодол, туршлагын талаарх мэдээллээ солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гаргасан. Зөвлөмжийг 19 аймгийн Засаг даргын Тамгын газарт албан тоотоор хүргүүлж, зөвлөмжийн дагуу орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар холбогдох арга хэмжээг аваад байна.</p> <p><u>II. Барилга угсралтын ажлын чиглэлээр:</u> 2022 онд “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд 9 аймгийн 18 сумын төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж</p>	НААИДБХЗГ 100	

					<p>байна. 2022 онд хийхээр төлөвлөгдсөн ажлын гүйцэтгэл 09 дүгээр сарын байдлаар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Архангай аймгийн Ихтамир сум. Гүйцэтгэгч “Бурхант хясаант” ХХК, ажлын гүйцэтгэл 80%, 2. Баянхонгор аймгийн Баацагаан сум. Гүйцэтгэгч “Рино инженеринг” ХХК, ажлын гүйцэтгэл 10%, 3. Баянхонгор аймгийн Галуут сум. Гүйцэтгэгч “Алегротовер констракшн” ХХК, ажлын гүйцэтгэл 80%, 4. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сум. Гүйцэтгэгч “Бридж бюлдинг” ХХК, ажлын гүйцэтгэл 85%, 5. Говь-Алтай аймгийн Алтай сум. Гүйцэтгэгч “Тунгалаг говь транс” ХХК, “Билгүүн од консракшн” ХХК түншлэл, ажлын гүйцэтгэл 15%, 6. Дорнод аймгийн Дашбалбар сум. Гүйцэтгэгч “Чандмань тал” ХХК, ажлын гүйцэтгэл 100%, 7. Дундговь аймгийн Луус сум. Гүйцэтгэгч “Бурхант хясаат” ХХК, ажлын гүйцэтгэл 70%, 8. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум. Гүйцэтгэгч “Юу зэт эрдэнэ” ХХК, ажлын гүйцэтгэл 20%, 9. Өвөрхангай аймгийн Хужирт сум. Гүйцэтгэгч “Хэмжил зүй” ХХК, ажлын гүйцэтгэл 20%, 10. Өвөрхангай аймгийн Уянга сум. 2022.09.21-нд барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын нээлтийг хийнэ. 11. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум. Гүйцэтгэгч “Бажамандал” ХХК, ажлын гүйцэтгэл 15%, 12. Төв аймгийн Баянчандмань сум. Гүйцэтгэгч “Эл си би” ХХК, ажлын гүйцэтгэл 70%, 13. Төв аймгийн Борнуур сум. Гүйцэтгэгч “Сайн констракшн” ХХК, ажлын гүйцэтгэл 60%, 14. Төв аймгийн Дэлгэрхаан сум. Гүйцэтгэгч “Төв төгөл” ХХК, ажлын гүйцэтгэл 70%, 15. Төв аймгийн Сэргэлэн сум. Гүйцэтгэгч “Баткомплект” ХХК, ажлыг гүйцэтгэл 90%, 16. Төв аймгийн Эрдэнэ сум. Гүйцэтгэгч “Билгүүн од констракшн” ХХК, ажлын гүйцэтгэл 90%, 17. Хэнтий аймгийн Галшар сум. Гүйцэтгэгч “Цагаан зуун” ХХК, ажлын гүйцэтгэл 95%, 18. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум. Гүйцэтгэгч “Санжат” ХХК, ажлын гүйцэтгэл 30%-тай тус тус 	
--	--	--	--	--	--	--

						<p>инженерийн дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэж байна.</p> <p><u>III. Зураг төсөл боловсруулах чиглэлээр:</u> “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд 4 аймгийн 10 суманд сумын төвийн инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум. Гүйцэтгэгч “ДНТ” ХХК, ажлын гүйцэтгэл 80%, 2. Төв аймгийн Алтанбулаг сум. Гүйцэтгэгч “Гидро дизайн инноваци” ХХК, ажлын гүйцэтгэл 95%, 3. Төв аймгийн Батсүмбэр сум. Гүйцэтгэгч “ДНТ” ХХК, ажлын гүйцэтгэл 95%, 4. Төв аймгийн Баян сум. Гүйцэтгэгч “Гидро дизайн инноваци” ХХК, ажлын гүйцэтгэл 95%, 5. Төв аймгийн Жаргалант сум. Гүйцэтгэгч “ДНТ” ХХК, ажлын гүйцэтгэл 95%, 6. Төв аймгийн Угтаалцайдам сум. Гүйцэтгэгч “ДНТ” ХХК, ажлын гүйцэтгэл 95%, 7. Төв аймгийн Эрдэнэсант сум. Гүйцэтгэгч “Гидро дизайн инноваци” ХХК, ажлын гүйцэтгэл 95%, 8. Ховд аймгийн Мянгад сум. Гүйцэтгэгч “ДНТ” ХХК, ажлын гүйцэтгэл 80%, 9. Хөвсгөл аймгийн Рашаант сум. Гүйцэтгэгч “ДНТ” ХХК, ажлын гүйцэтгэл 70%, 10. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум. Гүйцэтгэгч “ДНТ” ХХК, ажлын гүйцэтгэл 70%-тай тус тус сумын төвийн инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. 	
20	6.2.10. Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг	Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга	Барилга угсралтын ажлыг үе шаттайгаар гүйцэтгэсэн байна.	2022 онд улсын төсөвт нийт 103,8 тэрбум төгрөг туссан. Санхүүжилт олгогдоогүй байна.	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ /Төв аймаг, Эрдэнэ сум/. Гүйцэтгэл-20% 2.Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт/Төв аймаг, Сэргэлэн сум/, 3."Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл/ Архангай, Их тамир/ Гүйцэтгэл- 20% 	НААИДББХЗГ 100	

		<p>шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх</p>	<p>хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх</p>		<p>4."Ариутгах татуургын 3-р коллекторын төв шугам татах ажил /Орхон, Баян-Өндөр сум/ Гүйцэтгэл-14% 5."Сумыг хилийн боомтыг цэвэрлэх байгууламжтай холбох бохир ус зайлуулах шугам /Сэлэнгэ, Алтанбулаг сум/" Гүйцэтгэл-10% 6. Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт /Төв аймаг, Борнуур сум/ Гүйцэтгэл-10% 7."Залуус-1 хорооллын дулаан хангамжийн ажил" /Дархан-Уул аймаг, Дархан Сум/ Гүйцэтгэл-10% 8."Залуус-1 хорооллын цэвэр, бохир усны шугамын ажил" /Дархан-Уул аймаг, Дархан сум/ Гүйцэтгэл-10% 9.Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл 1,5 км /Говь-Алтай, Есөнбулаг сум/ Гүйцэтгэл-20% 10.Сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж. /Дундговь/. Гүйцэтгэл-80% 11.Цэвэр, бохир усны шугам сүлжээ /Хөвсгөл, Мөрөн сум/-ны ажил Гүйцэтгэл-100% 12. Цэвэр усны эх үүсвэрийн барилга, байгууламж, шугам хоолойн шинэчлэлтийн ажил. Гүйцэтгэл-56% 13.Инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Орхон, Баян-Өндөр сум, Дэнж баг/ Гүйцэтгэл-80% 14.Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/-ын ажил. Гүйцэтгэл-20% 15.Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл /Хөвсгөл, Мөрөн/ Гүйцэтгэл-100% 16.Инженерийн шугам сүлжээ бүхий гэр хорооллын төсөл /Хөвсгөл Мөрөн сум/ Гүйцэтгэл-70% 17.Гадна ус дулаан хангамж, ариутгах татуургын шугам, /Завхан/ Гүйцэтгэл-90% 18.Хилчин хотхоны инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 30 дугаар хороо/ Гүйцэтгэл-90% 19.Гэр хорооллын бохир усны шугам" /Хөвсгөл, Мөрөн сум/ Гүйцэтгэл-70% Нийт төсөл, арга хэмжээний хэрэгжилт 45%-тай.</p>	
--	--	--	--	--	---	--

21	6.2. Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	6.2.11. Хангайн бүсийн төв Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын зарим орон сууцны барилгыг дахин төлөвлөлтөд оруулах /Арвайхээр, Хужирт, Хархорин сумдын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх, Уянга, Бат-Өлзий сумдыг "Сумын хөгжил" арга хэмжээнд хамруулах/	Хангайн бүсийн төв Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын зарим орон сууцны барилгыг дахин төлөвлөлтөд оруулах /Арвайхээр, Хужирт, Хархорин сумдын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх, Уянга, Бат-Өлзий сумдыг "Сумын хөгжил" арга хэмжээнд хамруулах/	"Сумын хөгжил" арга хэмжээнд 2 сумыг хамруулсан байна.	Нийт төсөвт өртөг 17,900.0 сая төгрөг. 2022 онд санхүүжих төсөвт өртөг 3,5 тэрбум төгрөг.	1. Өвөрхангай аймгийн Хужирт сумын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах зорилгоор "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Төсөл хэрэгжүүлэгчээр "Хэмжил зүй" ХХК шалгарч, 2022.09-р сарын байдлаар төслийн ажлын явц 10%-тай. 2. "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээнд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумыг хамруулж барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Юу зэт эрдэнэ" ХХК шалгарч 2022.09-р сарын байдлаар төслийн ажлын гүйцэтгэл 15%-тай. 3. Өвөрхангай аймгийн Уянга суманд "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендерийг зарлан, дүгнэж байна.	НААИДББХЗГ 100
----	---	--	--	--	---	---	-------------------

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ